



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/94

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Хогийн цэг булшлах, шинэ талбай /Чандмань сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ж.Батсайхан - "Тогтвортой амьжиргаа" төслийн зохицуулагч

Гишүүдэд: Д.Батчимэг - Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн цалин хариуцсан нягтлан бодогч

Г.Сувдаа - Төрийн бус байгууллагын төлөөлөл

У.Эрдэнэцэцэг - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ж.Батсайхан/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 0558  
D/Tush-A/94-Bo